

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн

3 дахь 7 хоногт хийсэн ажил

- “Дэлхийн хэмжил зүйн өдөр”-ийг угтаж Баян-Өлгий аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсээс 2017 оны 5 дугаар сарын 14-ний өдөр харилцагч байгууллагуудын дунд гар бөмбөгийн тэмцээнийг амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд Мэргэжлийн хяналтын газар, ХХААГазар, Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Цахилгаан холбооны газар, Цахилгаан шугам сүлжээний газар, НИК-1, НИК-2, Магнай трейд, Хөрс ХХК, СУАТ ХХК, Файнноос ХХК, Эрчимбаян-Өлгий ХХК -ны баг тамирчид оролцлоо.
- Бүх нийтээр мод тарих үндэсний өдөрт Стандарт хэмжил зүйн хэлтсийн бүх ажилтнууд идэвхтэй оролцож 20 ш мод тарив.
- Аймгийн Засаг даргын удирдамжийн дагуу 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр хууль сурталчлах өдөрлөгт тус хэлтэст мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм журмыг хэлтсийн мэргэжилтнүүд ард иргэдэд сурталчилав.
- Хэлтсийн улсын шалгагч Х.Өмирбек Рысжан ХХК-ны ШТС-уудыг ээлжит баталгаажуулалтанд хамруулав.

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТЭС